

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2025 оны 05 сарын 27 өдөр

Дугаар А/17

Арвайхээр сум

Үнэлгээний багийн бүрэлдэхүүн байгуулах тухай

Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.2, Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 301 дүгээр тогтоолын хавсралтын 6 дугаар хэсгийн 6.1-ийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн газрын 2025 оны төрийн жинхэнэ албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, төрийн үйлчилгээний албан хаагчдын хөдөлмөрийн гэрээний хагас, бүтэн жилийн үнэлгээг дүгнэх үнэлгээний багийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний жилийн эцсийн үнэлгээг хууль журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний багийн дарга (Н.Оюунтуяа)-д даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтсийн дарга (Я.Жаргал), эхний хагас жил, сүүлийн хагас жилийн урамшууллыг тухайн жилийн төсөвт багтаан олгохыг ахлах нягтлан бодогч (Б.Валя) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Б.ГАНБАЯР

622501060

Эрүүл мэндийн газрын даргын
2025 оны .05 дүгээр сарын 27 өдрийн
А/17 дугаар тушаалын хавсралт



ҮНЭЛГЭЭНИЙ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Үнэлгээний багийн дарга: Н.Оюунтуяа /Удирдлага төлөвлөлтийн хэлтсийн дарга/
Нарийн бичгийн дарга: П.Оюунбилэг /Хүний нөөцийн мэргэжилтэн/
Гишүүд: Я.Жаргал /Хяналт-шинжилгээ, үнэлгээ, мэдээллийн хэлтсийн дарга/
Ю.Ичинноров /Эмнэлгийн тусламж, үйлчилгээний хэлтсийн дарга/
М.Золзаяа /Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга/
Б.Валя /Захиргаа санхүү, нийтлэг үйлчилгээний албаны дарга/
Ц.Эрхномуун /Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн мэргэжилтэн/

---oOo---